

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 269<sup>1</sup>.1.11 дэх заалт нэмсүгэй:

“269<sup>1</sup>.1.11.улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх.”

**2 дугаар зүйл.** Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“60.3.4.хуульд заасан бичиг баримт;”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “байгаль орчин, хилийн” гэснийг “байгаль орчны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>5</sup> дугаар зүйлийн 5<sup>5</sup>.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.9, 29.10, 29.11, 29.12, 29.13 дахь хэсэг нэмсүгэй:

29.9. Ашигт малтмал, газрын тос, бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, улс хоорондын тээврийн зохицуулалт, халдвар хамгаалал, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог нэгдсэн зохицуулалтаар хангах, боомтын хөгжлийн асуудлыг төлөвлөх, орон сууц, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус болон бусад дэд бүтцийг хариуцаж, боомтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хилийн боомт дахь төрийн өмчийн бүртгэл, хяналтыг хариуцах чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг Засгийн газар байгуулна.

29.10. Энэ хуулийн 29.9-д заасан Хилийн боомтын захиргааны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар, үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

29.11. Хилийн боомтын үндэсний зөвлөлийн санал болгосноор Хилийн боомтын захиргааны даргыг Засгийн газар томилж, чөлөөлнө.

29.12. Хилийн боомтын захиргаанаас хилийн боомтод төлөөлөгч томилон ажиллуулж болно.

**29.13. Хилийн боомтын захиргаа нь хилийн боомтод цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 29.9-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.**

**2 дугаар зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсгийн “гааль, мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 дахь заалтын “мэргэжлийн хяналт,” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.1, 17.3.2 дахь заалтын “мэргэжлийн хяналтын,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Эцэслэн батлах төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын “импортлох,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэсний дараа “, гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагч” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД  
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6, 17 дугаар зүйлийн 17.12 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Органик хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ... -ны өдөр

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН  
ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, гаалийн байгууллага” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хувиргасан амьд организмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хувиргасан амьд организмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэг:**

“6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйл, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 5.15, 6.1, 6.2 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 13, 14, 15, 16 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 ,6.12 дугаар зүйл, 6.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 6.19 дүгээр зүйл, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 6.24 дүгээр зүйл, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 8.1, 8.2, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, мөн зүйлийн 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 9.11, 9.12, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.16, 10.17, 10.19, 10.22, 10.24, 10.25, 10.27, 11.2 дугаар зүйл, 11.25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 12.12, 13.1, 13.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 13.5, 13.7, 13.9, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;”

#### **2/1.8 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:**

“6.11.гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 7, 9, 10 дахь хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 5.12 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, мөн зүйлийн 4 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 27 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалт, 6.4 дүгээр зүйлийн 1.1, 2.8 дахь

заалт, 6.5 дугаар зүйлийн 9,10 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 7.2 дахь заалт, 6.7 дугаар зүйлийн 9.3 дахь заалт, 6.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 1, 6 дахь хэсэг, 6.15 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 6.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.23 дугаар зүйл, 6.25 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 7.3 дугаар зүйл, 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9.7 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, 10.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 10.24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 11.21 дүгээр зүйл, 11.22 дугаар зүйл, 11.24 дүгээр зүйлийн 1.1, 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 11.29 дүгээр зүйлийн 22 дахь хэсэг, 13.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 13.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 15.2 дугаар зүйл, 16.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

### **АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:**

“2.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гаалийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

#### **2/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:**

“6.2. Энэ хуулийн 6.1-д заасан хорио цээрийн хяналт, шалгалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.”

#### **3/27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг:**

“27.1. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг гаалийн байгууллага олон улсын стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хилийн боомт, гүний гаалийн дэргэдэх мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 12.2, 12.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж, 7 дугаар зүйлийн гарчиг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “Улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “Гаалийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь

хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын төв” гэснийг “гаалийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “улсын” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 14.2 дахь хэсэг нэмсүгэй:

“14.2.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авна.”

**2 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийн 11<sup>1</sup>.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.12 дахь хэсэг, 13.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурсан агуулгатай 10.5 дахь хэсэг нэмсүгэй:

“10.5.Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 57.14 дэх хэсэг нэмсүгэй:

“57.14.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”

**2 дугаар зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “тухайн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

### **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.3 дахь заалт нэмсүгэй:

“9.1.3.Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах.”

**2 дугаар зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “дутагдалтай” гэсний дараа “иргэн, хуулийн этгээд,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

**4 дүгээр зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “9.1.1-д” гэснийг “9.1-д” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Засгийн газар.” гэснийг “энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани.” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7 дахь заалтын “эсэх асуудлаар” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

**ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.9 дэх хэсэг нэмсүгэй:

25.9.Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

### **Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай**

Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2022 онд гадаад, дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль  
баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авахыг чиглэл болгох;

2/Засгийн газраас дэвшүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн төрийн албанд ашиглаж байгаа суудлын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагаас бусад төрийн байгууллагуудын суудлын автомашины хэрэглээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр үе шаттай хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах;

3/2022 оны төсвийн жилд төсвийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа, бүтээгдэхүүний хэмжээг өмнөх оны хэмжээтэй харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх;

4/улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, үнийн өөрчлөлтийн индексийг батлах;

5/улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, холбогдох саналаа 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Улсын Их Хуралд танилцуулах;

6/Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх, хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх;

**7/төсвийг төлөвлөх, шат шатанд өргөн мэдүүлэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлж, ил тод, нээлттэй болгох;**

**8/Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, аудитын дүгнэлтэд дурдсан төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах асуудлыг судлан үзэж, шаардлагатай бол холбогдох хуулийн төслийг боловсруулж 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.**

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Занданбат/-т дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1/Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн төсөлд аудит хийсэн дүгнэлтээ Улсын Их Хуралд ирүүлэхдээ холбогдох судалгаа, тооцооллыг хавсаргадаг байх;

2/энэ тогтоолын 2.1 дэх дэд заалтад тусгагдсан аудитын дүгнэлтэд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах.

3.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөрУлаанбаатар  
хот**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ирээдүйн өв сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 9<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**1/9<sup>1</sup> дүгээр зүйл.Хүүхдийн мөнгөн хуримтлал**

9<sup>1</sup>.1.2022 оны төсвийн жилд Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор шаардагдах хөрөнгийг энэ хуулийн 7.1-д заасан тухайн жилийн эх үүсвэрээс олгоно.

9<sup>1</sup>.2.Энэ хуулийн 9<sup>1</sup>.1-д заасан шаардагдах хөрөнгийн хэмжээг Ирээдүйн өв сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулиар батална.

9<sup>1</sup>.3.Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийн дагуу хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгохтой холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

9<sup>1</sup>.4.Хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсвэл сард нэг удаа хүсэлт гаргаж энэ хуулийн 9<sup>1</sup>.1-д заасан мөнгөн хуримтлалаас тухайн сард доор дурдсан хугацаанд дараах хувиар тооцож мөнгөн хэлбэрээр авах эрхтэй:

Д/д	Хамрах хугацаа	Мөнгөн хэлбэрээр олгох хувь
1	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл	100 хувь
2	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал	50 хувь

**2 дугаар зүйл.**Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.3.Сангийн данснаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 7.1-д заасан орлогын эх үүсвэрийн тухайн жилийн гүйцэтгэлээс энэ хуулийн 9<sup>1</sup>.1-д заасан хөрөнгийг мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор Төрийн санд, үлдэх хэсгийг Ирээдүйн өв сангийн Монголбанкн дахь дансанд тус тус шилжүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “жил бүрийн улсын төсөвт тусгаж” гэснийг “Ирээдүйн өв сангийн тухайн жилийн төсвийн тухай хуульд тусгаж” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “энэ хуулийн 9.1-д” гэснийг “энэ хуулийн 9.1, 9<sup>1</sup>-д” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “улсын” гэснийг “нэгдсэн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2022 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1-д заасан эх үүсвэрээс Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд Төрийн санд хуримтлагдах мөнгөн хуримтлалын хэмжээг сар бүр 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тооцох бөгөөд 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийг сар бүр мөнгөн хэлбэрээр, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 50,000 /тавин мянга/ төгрөгийг сар бүр мөнгөн хэлбэрээр тус тус олгож болно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг